

**ИРГЭНИЙ ХЭРЭГ ШҮҮХЭД ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ,
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙГ ШҮҮХИЙН ПРАКТИКТ ХЭРЭГЛЭХЭД
АНХААРАХ ЗАРИМ АСУУДЛЫН ТАЛААР**

Улсын Их Хурлаас Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль 2014 оны 04 дүгээр сарын 24-ний өдөр батлагдаж, даган мөрдөх болсонтой холбогдуулан Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд шинээр орсон зарим зохицуулалтыг нэг мөр ойлгож, иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд зөв хэрэглэх явдлыг хангах зорилгоор Улсын Дээд шүүхийн Иргэний хэргийн танхимаас зөвлөмж болгох нь:

НЭГ:Эвлэрүүлэн зуучлах ажиллагаатай холбоотой зохицуулалт

1.1.Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн /цаашид ИХШХШТХ гэх/ 13, 25, 43, 67, 71, 75, 80, 91, 106, 125, 129, 132, 183 дугаар зүйлд орсон нэмэлт, өөрчлөлт болон шинээр нэмэгдсэн 74¹ дүгээр зүйл эвлэрүүлэн зуучлах ажиллагаатай холбоотой байна.

Талууд байгуулсан гэрээндээ маргаан гарвал эвлэрүүлэн зуучлах ажиллагаагаар шийдвэрлүүлэхээр тохиролцсон бол шүүхээс гадуур урьдчилан шийдвэрлэх журам тогтоосон гэж үзэх тухай ИХШХШТХ-ийн 13 дугаар зүйлийн 13.5 дахь хэсэгт заажээ.

Иймд хэрэв шаардлагын үндэслэл болсон гэрээг нэхэмжлэлд хавсаргасан байвал шүүх тухайн гэрээг сайтар уншин танилцаж, маргаан гарвал хэрхэн шийдвэрлэх талаар тохиролцсон байгааг судлах нь зүйтэй. Маргаан гарвал эвлэрүүлэн зуучлах ажиллагаагаар шийдвэрлүүлэхээр талууд гэрээндээ тохиролцсон байвал шүүх ИХШХШТХ-ийн 65 дугаар зүйлийн 65.1.1-д заасан үндэслэлээр нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзвал зохино.

Ийнхүү талууд тохиролцсон нь хэргийг шүүх хуралдаанаар хэлэлцэх үед илэрвэл ИХШХШТХ-ийн 117 дугаар зүйлд /ИХШХШТХ-ийн 13, 65.1.1/ заасны дагуу шийдвэрлэх боломжтой юм.

1.2.Нэхэмжлэлийг хүлээн авч хэрэг үүсгэсэн шүүгч эвлэрүүлэн зуучлах ажиллагааны талаархи мэдээллийг хэргийн оролцогчид бүрэн өгч, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны бүх шатанд эвлэрэх, эвлэрүүлэн зуучлагчийн туслалцаа авах боломжийн талаар ИХШХШТХ-ийн 67 дугаар зүйлийн 67.1.4-т заасны дагуу танилцуулахдаа мөн хуулийн 25 дугаар зүйлийн 25.1.7, 74¹дүгээр зүйлийн 74¹.1.8, 74¹.1.9,106 дугаар зүйлийн 106.2, 132 дугаар зүйлийн 132.2, 183 дугаар зүйлийн 183.1 дэх хэсгийг тухайлан тайлбарлавал зохино. Үүнд:

а/.ИХШХШТХ-ийн 25 дугаар зүйлийн 25.1.7-т заасны дагуу хэргийн оролцогч нэхэмжлэлийн бүх шаардлага, эсхүл аль нэг буюу хэд хэдэн шаардлагатай холбогдуулан хэргийг эвлэрүүлэн зуучлах журмаар шийдвэрлүүлэх хүсэлт гаргах эрхтэй байна.

б/.Зохигчид эвлэрэх хүсэлтэй байгаа талаар хэргийг шүүх хуралдаанаар хэлэлцэх үед илэрхийлбэл эвлэрүүлэн зуучлагчийн туслалцаа авах эсэхийг шүүгч тодруулбал зохино.

в/.Зохигчид эвлэрүүлэн зуучлах журмаар эвлэрсэн бол давж заалдах, хяналтын журмаар гомдол гаргах, тухайн асуудлаар анхан шатны шүүхэд дахин нэхэмжлэл гаргах эрхгүй, эвлэрлийн гэрээг баталгаажуулсан захирамжийг талууд сайн дураар биелүүлээгүй бол шүүхийн шийдвэрийн нэгэн адил албадан гүйцэтгэх талаар хуульд заасан байна.

г/.Гэр бүлийн маргаантай хэргийг шүүх шийдвэрлэх үед хэргийг эвлэрүүлэн зуучлагч руу шилжүүлэх хүсэлтийг зохигчид гаргах эрхтэй бөгөөд уг асуудлаар эвлэрүүлэн зуучлах ажиллагаа өмнө нь явагдаж амжилтгүй болсон нь хүсэлтийг хангахад саад болохгүй юм.

1.3.Эвлэрүүлэн зуучлагчийн дэмжлэгтэйгээр байгуулсан эвлэрлийн гэрээг баталгаажуулах /ИХШХШТХ-ийн 74¹ дүгээр зүйл/.

а/.Нэхэмжлэлийг шүүх хүлээн авч иргэний хэрэг үүсгэхээс өмнө нэхэмжлэгч эвлэрүүлэн зуучлагчид хандах хүсэлт гаргавал шүүгч захирамж гаргаж нэхэмжлэлийг тухайн шүүх дэх эвлэрүүлэн зуучлагчид шилжүүлнэ. /ИХШХШТХ-ийн 74¹.1/

Талууд эвлэрсэн бол шүүгч эвлэрлийн гэрээг хүлээн авснаас хойш 7 хоногийн дотор гэрээг баталгаажуулах захирамж гаргана. /ИХШХШТХ-ийн 74¹.3, 74¹.5, 74¹.7/

Харин байгуулсан гэрээ нь ойлгомжгүй, тодорхой бус, эсхүл Иргэний хуульд нийцээгүй, гуравдагч этгээдийн хуулиар хамгаалагдсан ашиг, сонирхлыг хөндсөн байвал баталгаажуулахаас татгалзана. /ИХШХШТХ-ийн 74¹.7/

Эвлэрүүлэн зуучлал амжилтад хүрээгүй бол нэхэмжлэлийг хүлээн авч, иргэний хэрэг үүсгэж, хэргийг ердийн журмаар хянан шийдвэрлэнэ.

б/.Иргэний хэрэг үүсгэснээс хойш талууд эвлэрүүлэн зуучлагчийн дэмжлэгтэйгээр эвлэрэх хүсэлт гаргасан, эсхүл шүүх эвлэрүүлэн зуучлалыг зохистой гэж үзэж санал болгосныг зохигчид зөвшөөрсөн бол шүүгч захирамж гарган хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг түдгэлзүүлж, нэхэмжлэлийг тухайн шүүх дэх эвлэрүүлэн зуучлагчид шилжүүлнэ. /ИХШХШТХ-ийн 80.1.9, 74¹.1/

Шүүх иргэний хэрэг үүсгэснээс хойш явагдах эвлэрүүлэн зуучлах ажиллагааны хугацааг Эвлэрүүлэн зуучлалын тухай хуулийн 20 дугаар